



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/92

Есөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам” А/254 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны эм, эмнэлгийн хэрэгсэл, лаборатори, урвалж бодис худалдан авах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Ш.Насан	(Орон нутаг судлах музейн дарга)
Гишүүдэд:	Л.Оюундарь	(Нэгдсэн эмнэлгийн чих, хамар, хоолойн их эмч)
	Ё. Нарангарав	Хөндлөнгийн төлөөлөл (тохиролцсоноор)
	Ш.Батзүсэм	(Есөнбулаг сумын иргэн)
Нарийн бичиг:	А.Бямбадорж	(Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулж, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Ш.Насан)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ